



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

**Мөнгөн Улаанбаатар өвлийн спорт
наадмын цасны баярын арга хэмжээ
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2014 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2017 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадмыг 2017 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Хүй долоон худаг дахь “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын цанын баазад зохион байгуулагдах арга хэмжээнд нийт албан хаагчдыг өргөнөөр оролцуулахыг Спортын хамтлагийн ахлагч /Ц.Мөнхбат/-д даалгасугай.
2. Өвлийн спортын арга хэмжээнд оролцох иргэд, зорчигчдын нийтийн тээврийн үйлчилгээний маршрутын төлөвлөлт, зураглал гаргахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, үйлчилгээг зохицуулан зохион байгуулахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээний хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /С.Нямдорж/-т үүрэг болгосугай.
3. Арга хэмжээнд зарцуулагдах 632.850 /зургаан зуун гучин хоёр мянга найман зуун тавь/ төгрөгний зардлын төсвийг хавсралт ёсоор баталж бараа, үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /П.Долгормаа/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ДОТГОНБААТАР

Нийслэлийн Тээврийн газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 04 ны өдрийн
1109 дугаар тушаалын хавсралт



ӨВЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТИЙН ӨДӨРЛӨГТ
ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/Д	Зардлын төсөв	Хэмжээ / тоо, ширхэг, /	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төгрөг/	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Гэр	2	80 000	160.000	
2	Түлээ, нүүрс	6 боодол	20 000	40.000	
3	Шатахууны зардал	70	1 730	121.100	
4	Эко хүнс	1	100 000	100.000	
5	Спортын тэмцээний шагнал	1 байр 2 байр 3 байр	30 000 20 000 10 000	90.000 60.000 30.000	
6	Спорт хамтлагийн суртачилгааны самбар	1 ширхэг	31 750	31.750	
	ДҮН			632.850	

